

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/25/НА-СТА-ОНА

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.mn">bolort@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10-13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. Аудитын тайлан	14-16
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. Аудитын илрүүлэлт	17-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХС	Аймаг хөгжүүлэх сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төрийн албан хаагч
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ ОРОН СУУЦ” ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ М.ТЭМҮҮЛЭН ТАНАА

2024.03.15 № СЭА-2024/25/НА-СТА-ОНА  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд “Ганмон Энжелс” ХХК-ийн 147,157.5 мянган төгрөгийн зээлийн төлбөрт Цагааннуур суманд баригдсан 3 орон сууцыг шилжүүлэн авч, гэрээ хийн уг аж ахуйн нэгжийн зээлийн үлдэгдлээс хасаж тооцсон байна.

### Аудитын гол асуудал

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2022 оны эцэст бүртгэгдсэн 1,521,192.4 мянган төгрөгийн “Аймаг хөгжүүлэх сан”-гийн зээлийн үлдэгдлээс тайлант онд 4 аж ахуйн нэгжийн 180,852.6 мянган төгрөгийн, 10 иргэний 31,700.0 мянган төгрөгийн нийт **212,553.1** мянган төгрөгийн зээл төлөгдөж, 15 аж ахуйн нэгжийн 800,390.1 мянган төгрөгийн, 35 иргэний 508,249.2 мянган төгрөгийн зээл нийт **1,308,639.3** мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь тайлант онд 3 зорилт, 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82.9 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь *(Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл)* санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	847,559,671.11	1,991,142,562.16
1.1.2	Дансны авлага	4,000,399,207.10	3,081,805,549.17
1.1.4	Бусад авлага	1,613,462,839.36	1,308,447,282.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		1,320,000.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,461,421,717.57</b>	<b>6,382,715,393.33</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	559,999.80	19,567,035.24
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>559,999.80</b>	<b>19,567,035.24</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,461,981,717.37</b>	<b>6,402,282,428.57</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.3	Татварын өр	501,002.00	
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,356,969.63	
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,857,971.63</b>	-
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	50,000,000.00	
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>50,000,000.00</b>	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>51,857,971.63</b>	
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: Төрийн	908,960.00	908,960.00
2.3.2	ТӨҮГ	4,338,060,572.22	4,338,060,572.22
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,071,154,213.52	2,063,312,896.35
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>6,410,123,745.74</b>	<b>6,402,282,428.57</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,461,981,717.37</b>	<b>6,402,282,428.57</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>614,670,562.36</b>	
2	Борлуулалтын өртөг	675,061,263.84	
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(60,390,701.48)</b>	-
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	18,160,817.21	104,745,129.50
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	596,509,745.15	11,761,651.89
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	48,904,833.84	122,211,511.13
11	Санхүүгийн зардал	26,156,430.00	25,080,440.00
12	Бусад зардал	600,000,000.00	50,000,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(60,390,701.48)</b>	<b>(80,785,169.74)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(60,390,701.48)</b>	<b>(80,785,169.74)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(60,390,701.48)</b>	<b>(80,785,169.74)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
1	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	4,338,969,532.22	2,131,544,915.00	<b>6,470,514,447.22</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
3	Залруулсан үлдэгдэл			-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(60,390,701.48)	<b>(60,390,701.48)</b>
5	Бусад дэлгэрэнгүй орлого			-
6	Өмчид гарсан өөрчлөлт			-
7	Зарласан ногдол ашиг			-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
9	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,338,969,532.22</b>	<b>2,071,154,213.52</b>	<b>6,410,123,745.74</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-
11	Залруулсан үлдэгдэл			-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		(80,765,169.74)	<b>(80,765,169.74)</b>
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-
14	Өмчид гарсан өөрчлөлт		72,923,852.57	<b>72,923,852.57</b>
15	Зарласан ногдол ашиг			-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			-
17	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,338,969,532.22</b>	<b>2,063,312,896.35</b>	<b>6,402,282,428.57</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>743,040,715.12</b>	<b>116,506,781.39</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	743,040,715.12	
	Бусад мөнгөн орлого		116,506,781.39
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>75,061,263.84</b>	<b>197,291,951.13</b>
	Ажиллагчдад төлсөн	40,509,701.55	70,588,844.46
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,395,132.29	9,064,259.56
	Бараа материал худалдан авахад төлсөн	4,168,530.00	6,627,361.99
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,456,000.00	16,340,400.00
	Бусад мөнгөн зарлага	9,531,900.00	94,671,085.12
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>667,979,451.28</b>	<b>(80,785,169.74)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>169,576,940.73</b>	<b>1,299,448,500.79</b>
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	151,416,123.52	1,299,448,500.79
	Хүлээн авсан хүүний орлого	18,160,817.21	
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>-</b>	<b>25,080,440.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		23,760,440.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		1,320,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>169,576,940.73</b>	<b>1,274,368,060.79</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>-</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>600,000,000.00</b>	<b>50,000,000.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	600,000,000.00	50,000,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(600,000,000.00)</b>	<b>(50,000,000.00)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>		
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>237,556,392.01</b>	<b>1,143,582,891.05</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>610,003,279.10</b>	<b>847,559,671.11</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>847,559,671.11</b>	<b>1,991,142,562.16</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Нийт орлогын дүн</b>	<b>1,072,769,171.59</b>	<b>1,491,035,722.18</b>	<b>(418,266,550.59)</b>	<b>138.99</b>
<b>1.1</b>	<b>Авлагын барагдуулалт</b>	<b>982,769,171.59</b>	<b>1,374,528,940.79</b>	<b>(391,759,769.20)</b>	<b>139.86</b>
1.1.1	ТАХ-ийн орон сууцны зээлийн барагдуулалт	790,916,699.59	1,120,244,822.79	(329,328,123.20)	141.64
1.1.2	Сумдад хэрэгжсэн орон сууцны зээлийн барагдуулалт	41,852,472.00	41,731,038.00	121,434.00	99.71
1.1.3	АХС-ийн авлага барагдуулалт	150,000,000.00	212,553,080.00	(62,553,080.00)	141.70
<b>1.2</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>	<b>90,000,000.00</b>	<b>116,506,781.39</b>	<b>(26,506,781.39)</b>	<b>129.45</b>
1.2.1	Хүү алдангийн орлого	90,000,000.00	116,506,781.39	(26,506,781.39)	129.45
<b>2</b>	<b>Нийт зардлын дүн</b>	<b>181,020,508.86</b>	<b>147,291,951.13</b>	<b>33,728,557.73</b>	<b>81.37</b>
<b>2.1</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>86,982,597.20</b>	<b>70,588,844.46</b>	<b>16,393,752.74</b>	<b>81.15</b>
2.1.1	Үндсэн цалин	61,737,012.00	50,664,202.28	11,072,809.72	82.06
2.1.2	Нэмэгдэл цалин	12,880,819.20	14,389,949.18	(1,509,129.98)	111.72
2.1.3	Үр дүнгийн урамшуулал	5,740,766.00	2,036,693.00	3,704,073.00	35.48
2.1.4	Унаа хоол	6,624,000.00	3,498,000.00	3,126,000.00	52.81
<b>2.2</b>	<b>Ажил олгогчоос төлөх НДШ</b>	<b>10,437,911.66</b>	<b>9,064,259.56</b>	<b>1,373,652.10</b>	<b>86.84</b>
<b>2.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны зардал</b>	<b>83,600,000.00</b>	<b>67,638,847.11</b>	<b>15,961,152.89</b>	<b>80.91</b>
2.3.1	Бичиг хэрэг	5,600,000.00	5,877,361.99	(277,361.99)	104.95
2.3.2	Тээвэр шатахуун	18,000,000.00	16,340,400.00	1,659,600.00	90.78
2.3.3	Сургалт семинарын зардал	2,000,000.00	1,620,000.00	380,000.00	81.00
2.3.4	Шуудан холбооны зардал	500,000.00	629,910.00	(129,910.00)	125.98
2.3.5	Дотоод албан томилолт	6,000,000.00	4,930,600.00	1,069,400.00	82.18
2.3.6	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,500,000.00	750,000.00	1,750,000.00	30.00
2.3.7	Техник, тоног төхөөрөмж	13,000,000.00	12,924,670.00	75,330.00	99.42
2.3.8	Тавилга, эд хогшил	11,000,000.00	10,835,770.00	164,230.00	98.51
2.3.9	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,287,960.00	712,040.00	85.76
2.3.10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	20,000,000.00	9,442,175.12	10,557,824.88	47.21
<b>3</b>	<b>ТАХ-ын орон сууцны хөрөнгө оруулалтын зээлийн эргэн төлөлт</b>	<b>50,000,000.00</b>	<b>50,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 ОНӨААТҮГ, түүний үйл ажиллагаа**

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь *“Сэлэнгэ аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх”* гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлого, чиг үүргийг хэрэгжүүлэх,
- Гадаад, дотоодын хөрөнгийн зах зээлээс санхүүжилтийн эх үүсвэр татах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулах замаар хөрөнгийн тогтвортой сан бүрдүүлж, барилгын хөрөнгө оруулалт, зээл санхүүжилтийг цогцоор нь шийдвэрлэх,
- Төрийн өмнөөс аймгийн нутаг дэвсгэрт орон сууц бариулах ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон хувийн аж ахуйн нэгж, байгууллагатай орон сууц, үл хөдлөх хөрөнгийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор гэрээгээр болон хамтарсан аж ахуйн нэгж байгуулах зарчмаар хамтран ажиллаж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх,
- Залуу гэр бүл болон төрийн албан хаагчдад чиглэсэн орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урт хугацааны, хямд түрээсийн орон сууцны менежментийг хэрэгжүүлэх,
- Сумдын төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан эхлүүлэх гэх мэт.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

#### **3.2 ОНӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин**

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХТ-ийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 53 дугаар тогтоолоор байгуулагдсан байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь *“Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”*, 20 дугаар зүйлийн 20.1 дэх *“Орон нутгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна”*: 20.1.9: *“орон сууц, нийтийн аж ахуй”*, 35 дугаар зүйлийн 35.1 дэх *“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 35.1.12: орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй: ... 4/ “орон нутгийн*

өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон гэх мэт.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,699.3 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	847,559.7	1,991,142.6	1,143,582.9
<b>Нийт авлага</b>	<b>5,613,862.0</b>	<b>4,390,252.8</b>	(1,223,609.2)
Авлага /орон сууц/	4,000,399.2	3,081,805.5	(918,593.7)
Авлага /АХС/	1,613,462.8	1,308,447.3	(305,015.6)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	1,320.0	1,320.0
Үндсэн хөрөнгө	560.0	19,567.0	19,007.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,461,981.7</b>	<b>6,402,282.4</b>	<b>(59,699.3)</b>
Богино хугацаат өр төлбөр	1,858.0	-	(1,858.0)
Урт хугацаат өр төлбөр	50,000.0	-	(50,000.0)
Эздийн өмч	6,410,123.7	6,402,282.4	(7,841.3)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>6,461,981.7</b>	<b>6,402,282.4</b>	<b>(59,699.3)</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,991,142.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,143,582.9 мянган төгрөгөөр өссөн нь АХС болон ТАХ-ийн орон сууцны зээлийн эргэн төлөлтөөс,
- Авлагын дансны үлдэгдэл 4,390,252.8 мянган төгрөг болж, 1,223,609.2 мянган төгрөгөөр буурсан нь ТАХ-ийн 120 айлын орон сууцны эргэн төлөлтөөс 1,120,244.8 мянган төгрөг, Алтанбулаг, Баянгол, Цагааннуур сумын орон сууцны эргэн төлөлтөөс 41,731.0 мянган төгрөг, АХС-ийн зээлийн үлдэгдлээс 212,553.1 мянган төгрөгийг барагдуулснаас,
- Урт хугацаат өр төлбөрийн данс үлдэгдэлгүй болсон нь 2019 онд “Бүрнээ Мөнхбат” ХХК, “Таванхан Уул” ХХК, “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын байгуулсан гуравласан гэрээний дагуу 50,000.0 мянган төгрөгийг төлж барагдуулснаас шалтгаалсан байна.

### 3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/34 дүгээр захирамжаар “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны төлөвлөгөөг баталж, авлагын барагдуулалтыг 982,769.2 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 90,000.0 мянган төгрөгөөр, нийт орлогыг 1,072,769.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 181,020.5 мянган төгрөгөөр, урт хугацааны хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг 50,000.0 мянган төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Гүйцэтгэлээр авлагын барагдуулалтаар 1,374,528.9 мянган төгрөг, хүү алдангийн орлого 116,506.8 мянган төгрөг, нийт 1,491,035.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урт хугацааны хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд 50,000.0 мянган төгрөг, үйл ажиллагаанд 147,292.0 мянган төгрөгийн зардал гарган, 80,785.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого 1,491,035.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөгөөг 418,266.5 мянган төгрөгөөр буюу 39.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 147,292.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 33,728.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь цалин, НДШ-ийн зардлыг 17,767.4 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны зардлыг 15,961.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, зардлын данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт авлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт авлагын 5,627,745.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **56,277.4** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг мөрдөж, баталсан төлөвлөгөөний хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ орон сууц” ОНӨААТҮГ-ын мэдээлбэл зохих 26 төрлийн 158 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл, худалдан авах ажиллагаа нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 46,981.3 мянган төгрөгийн албан шаардлага, 2,840.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	46,981.3	2	46,981.3	100
Зөвлөмж	1	2,840.0	1	2,840.0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>49,821.3</b>	<b>3</b>	<b>49,821.3</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус үйлдвэрийн газарт 2022 оны жилийн эцэст бүртгэгдсэн 1,521,192.4 мянган төгрөгийн АХС-ийн зээлийн үлдэгдлээс тайлант онд 212,553.1 мянган төгрөгийн зээл төлөгдөж, 1,308,639.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

АХС-ийн зээлийн үлдэгдлээс тайлант онд **212,553.1** мянган төгрөгийг /1 хоршоо, 4 иргэний зээл бүрэн төлөгдсөн/ барагдуулсан байна. Үүнд:

- “Нийслэл хүнс трейд” ХХК, “Бум-Эрдэнэ” ХХК, “Арвин ургац цэцэглэнэ” хоршооны нийт 33,695.5 мянган төгрөгийн,
- 10 иргэний нийт 31,700.1 мянган төгрөгийн,
- “Ганмон Энжелс” ХХК-ийн зээлийн үлдэгдлээс нийт 147,157.5 мянган төгрөгийн үнэ бүхий Цагааннуур сумын 3 орон сууцыг шилжүүлэн авч гэрээ хийн, тайлант онд уг аж ахуйн нэгжийн зээлийн үлдэгдлээс хасаж тооцсон байна.

2023 оны жилийн эцэст тус үйлдвэрийн газарт 15 аж ахуйн нэгжийн 800,390.1 мянган төгрөгийн, 35 иргэний 508,249.2 мянган төгрөгийн нийт **1,308,639.3** мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл тайлагнагдсан байна. Үүнд:

- Нийслэлийн ШШГГ, аймгийн ШШГГ, Мандал, Сайхан сумын ШШГХ-ийн гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа 32 зээлдэгчийн 898,868.7 мянган төгрөгийн,
- Нас барсан 5 зээлдэгчийн 105,000.0 мянган төгрөгийн,
- Гадаадад байгаа 3 зээлдэгчийн 58,930.0 мянган төгрөгийн,
- Шүүхээр эвлэрлийн гэрээ байгуулсан 1 зээлдэгчийн 5,630.0 мянган төгрөгийн,
- Эрэн сурвалжилж байгаа 1 зээлдэгчийн 20,000.0 мянган төгрөгийн,
- Тогтмол төлж байгаа 1 зээлдэгчийн 70,800.0 мянган төгрөгийн,
- Шүүхэд шилжүүлэхээр шийдвэрлэсэн 2 зээлдэгчийн 25,863.0 мянган төгрөгийн,
- Шүүхэд эвлэрэлд хүргүүлсэн боловч хүрэлцэн ирээгүй 2 зээлдэгчийн 70,000.0 мянган төгрөгийн,
- Ажиллагаа явуулаагүй 3 иргэн, 1 аж ахуйн нэгжийн 53,547.6 мянган төгрөгийн зээл бүртгэлтэй байна.

Цаашид хугацаа хэтэрсэн 8 зээлдэгчийн 149,410.6 мянган төгрөгийн зээлийн асуудлыг гэрээний дагуу хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, өмнө гарсан шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч үлдэгдэл авлагыг бүрэн барагдуулах нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 1 алдааг арилгах зөвлөмж өглөө. Үүнд:

- Тус байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 3 нэгж талбарын 5.6 га газрыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус байгууллагын эзэмшилд бүртгэгдсэн 5.6 га газрыг 2024 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд тусгах.

Аудитаар нийт **18,223.3** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **4,558.3** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **13,665.0** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **2** зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас 3 албан хаагчид олгосон **4,558.3** мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг дутуу суутгасан боловч авлагаар тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2: "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу суутгасан цалингийн урьдчилгааг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Төрийн албан хаагчтай байгуулсан орон сууц захиалгаар барих гэрээний үүргийн биелэлтийн дагуу төвлөрүүлэх орлогоос **6** албан хаагчийн **12,497.0** мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", Төрийн албан хаагчтай байгуулсан "Орон сууц захиалгаар барих" гэрээний 2.2 дахь "Захиалагч нь үл хөдлөх эд хөрөнгийн төлбөрийг энэхүү гэрээнд заасан хуваарийн дагуу төлнө" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргийг биелэлтийг хангуулах албан шаардлага хүргүүлэв.

2. Анхан шатны баримтын бүрдэлгүй буюу албан томилолтын хуудасгүйгээр **1,168.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөөгүй буюу нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1: Анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2: Журналд бичих, 14.3.3: Дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4: Ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5: Санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд программ ашиглах замаар бүртгэлийг холбогдох дарааллаар хөтлөх зөвлөмж өгөв.

#### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Аймгийн ГХБХБГ-т үндсэн орон тоонд нягтлан бодогчоос гадна Стандарт, хэмжил зүйн хэлтсийн нягтлан бодогчийн үүргийг гүйцэтгэж, 80.0 хувийн цалин авч буй Б.Уранчимэгийг хөдөлмөрийн гэрээгээр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина”, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: 3 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өгөв.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>1</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Газрыг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	-	1	-					1	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас цалингийн урьдчилгааг дутуу суутгаж, авлага үүсгэсэн.	1	4,558.3	1	4,558.3								

/мянган төгрөгөөр/

Үүнээс

ТАХ-ийн орон сууцны гэрээт орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	12,497.0		1	12,497.0				
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	1,168.0		1	1,168.0				
Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг холбогдох дарааллын дагуу гүйцэтгээгүй.	1	-				1	-		
Зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр 3 байгууллагад нягтлан бодогчийн ажил эрхэлсэн.	1	-				1	-		
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>18,223.3</b>	<b>1</b>	<b>4,558.3</b>	<b>2</b>	<b>13,665.0</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс				/мянган төгрөгөөр/
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Төлбөрийн акт		Албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
<b>Дүн</b>									
<b>Нийт дүн</b>									